

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

### **Орон нутгийн хөгжлийн сан:**

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2014 оны 12 дугаар сарын 18-ны Монгол Улсын 2014 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 9253.6 сая төгрөг болгон 691.7 сая төгрөгөөр бууруулан баталсан боловч гүйцэтгэлээр 6864.6 сая төгрөг олгон төлөвлөснөөс 2389.0 сая төгрөг буюу 27.9 хувиар, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдад 3990.1 сая төгрөгийн санхүүжилт олгож төлөвлөснөөс 1562.0 сая төгрөг буюу 28.1 хувиар тус тус дутуу санхүүжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05/04 тоот тогтоолоор 2014 онд сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүгийн дэмжлэгийг 5967.2 сая төгрөгөөр баталсныг 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 08/01 тоот тогтоолоор 5552.1 сая төгрөг болгон 415.1 сая төгрөгөөр буюу 6.95 хувиар бууруулан баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 8 дугаар хуралдаанаар төсөвт тодотгол хийж орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүжилтийг 415.1 сая төгрөгөөр хорогдуулсан байхад Баян-Агт, Сайхан, Тэшиг, Хутаг-Өндөр, Бугат, Тэшиг, Бүрэгхангай сумдууд төсөвтөө тодотгол хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтыг зөрчсөн байна.

**Аймгийн орон нутгийн хөгжлийн санд** оны эхний үлдэгдэл 794.4 сая төгрөг дээр орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр 6864.6, сумдаас морин хуур, хувцасны 87.7, зураг төсвийн эргэн төлөлтөөр 35.0, Булган сумаас баяр наадмын 10,0 нийт 6997.3 сая төгрөгийн санхүүжилт авч сумдын орон нутгийн хөгжлийн санд 4757.8, 18 төсөл арга хэмжээнд 1941.1 нийт 6699.1 сая төгрөг зарцуулж 1092.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Аудитан дүнгээс

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг хуулийн дагуу тооцогдож хуваарилагдаж байгаа боловч төсвийн жилийн хугацаанд санхүүжилт хугацаандаа хийгдэхгүй байгаагаас “Төсвийн тухай хууль”-ийн 59.2 дахь заалт зөрчигдсэн .
- Орон нутгийн хөгжлийн сангаас аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг “Төсвийн тухай хууль”-ийн 59.2, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 264, 290 дүгээр тогтоолын дагуу тооцож сумдад олгож байгаа боловч төсвийн орлого бүрдүүлэлт, санхүүжилтээс шалтгаалан оны эхнээс сумдад жигд хуваарилан олгохгүй оны эцсээр санхүүжилт очдогоос шалтгаалан сумдын төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ, тайлант жилдээ хэрэгжихгүй, огт хэрэгжүүлээгүй ажлын тоо нэмэгдсэн.
- Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн иргэдийн санал авч нэгдсэн жагсаалтыг гарган багийн иргэдийн нийтийн хурлын тогтоолоор батлан эрэмбэлсэн саналыг сумын ЗДТГ тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж төсвийн төсөлд тусган сумын ИТХ-аараа батлан хэрэгжүүлж байгаа боловч зарим сум нийт иргэдээ санал авах ажиллагаанд бүрэн хамруулах ажил дутагдалтай байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, их засварын ажлууд нь ТЭЗҮ, зураг төсөв нь өмнө хийгдээгүй ажилд хөрөнгө

батлагдаж, хугацаа алдах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль зөрчиж гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн.

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах талаар хууль, журамд тусгасан заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, тэдгээрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтийн хяналтад оруулах ажлыг зохион байгуулаагүй.
- Сумдын удирдлага, тухайн ажил хариуцсан албан тушаалтнуудын ОНХС-ийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах мэдлэг чадвар дутмаг, хариуцлага сул байна
- Орон нутгийн өмчид бүртгэгдсэн хөрөнгийн ашиглалтыг хариуцаж хяналт тавьж ажиллахыг ашиглагч байгууллагуудад хариуцуулсан боловч арчлалт, хамгаалалт хангалтгүйгээс нийтийн зориулалтын эд хөрөнгө үрэгдэж эзэнгүйдэж байна.
- Зураг төсөв, ерөнхий төлөвлөгөөний ажлууд экспертизээр хянагдаж эцсийн байдлаар гарч ирэхэд хугацаа их шаардаж байгаа, үүнтэй холбоотойгоор гэрээний хугацаа хойшилдог, хэрэгжүүлэх ажлууд нь оройтдог он дамждаг асуудал гарч байна.
- Өмнө хийгдсэн ажлуудын ашиглалтын зардлыг санхүүжүүлдэг. Сангийн сайдын 43 дугаар тушаалаас хойш зарим сумд зардал гаргахыг зогсоосон зарим нь өөр эх үүсвэр, батлагдсан төсөв байхгүй учир санхүүжилтийг олгосон байна. Хогны автомашин, тракторын шатахуун, жолоочийн цалин, НДШ, гудамжны гэрэлтүүлгийн цахилгааны зардлууд, багийн Засаг даргыг унаажуулах цагдаагийн автомашин авсан.
- Зарим сумд нь иргэдийн санал аваагүй ажлыг ИТХ-аар баталдаг, мөн ИТХ-аар батлаагүй төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн.
- Суурь нөхцөл үүсээгүй байхад сангийн хөрөнгөөр бэлтгэж хөрөнгийг зориулалтаар нь ашиглахгүй агуулахад хадгалах, тооцоолсон үр ашиг, үр дүн гарч байгаа эсэхийг хянаж, үр дүнг тооцож ажиллаагүй байна гэж дүгнэлээ.

#### **Хангал сум:**

Сумын ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 7-р хуралдааны 1/46 тоот хуралдаанаар 2014 оны орон нутгийн төсвийн орлогыг 54694.1 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2014 оны 12-р сарын 25-ны 1/91 тоот тогтоолоор орон нутгийн орлогыг 138137.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Сумын татварын орлогыг сүүлийн 2 жилээр харьцуулбал хувиараа аж ахуй эрхэлсэний орлогын албан татвар 204.0, хувиараа материал бэлтгэсний орлогын албан татвар 1814.0, ойгоос мод түлээ бэлтгэж ажилласны төлбөр 4025.7, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 81772.5, хог хаягдал 365.6, төсөвт байгууллагын өөрийн орлого 1331.0 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос өссөн байна.

Дээрх байдлаас харахад түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр өмнөх оноос 81772.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрдэнэт үйлдвэр ХХК-аас оруулсан орлоготой холбоотой байна.

#### **Аудитын дүнгээс:**

- Тайлант онд орон нутгийн төсвийн орлогыг 138137.0 мянган төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 140719.2 мянган төгрөг орж 2582.5 мянган төгрөгөөр

давсан ба 4698.0 мянган төгрөгийн 7 нэр төрлийн орлого давж, 2115.5 мянган төгрөгийн 4 нэр төрлийн орлого тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41.2. "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ" 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

- Засаг даргын тамгын газрын төсвөөс анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гаргасан нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7. "анхан шатны баримт бүрдүүлээгүй,... байх"-ыг нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хориглосныг, Төсвийн тухай хуулийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэсэн заалт болон Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг зөрчсөн.
- Засаг даргын нөөцийн сангаас анхан шатны баримтгүй 72.1 мянган төгрөгийн шатахууныг гаргаж бүртгэл, тайланд тусгасан, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2.1, 2.2, 2.3-д заагдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна гэж заасныг зөрчин шинэ жилийн үйл ажиллагаанд 165.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан, Засаг даргын нөөцийн сангийн бүртгэлийн данснаас хийгдсэн 852.3 мянган төгрөгийн ажил гүйлгээнд даргын тамга гарын үсэг дутуу, ажил гүйлгээг гаргасан төлбөрийн хүсэлтэн дээр эдийн засгийн ангилал болон шилжүүлгийн мөнгөн дүнг баллаж зассан, төрийн сангийн мэргэжилтний хянаж баталгаажуулсан гарын үсэг, тэмдэггүй баримтаар ажил гүйлгээг гаргасан зөрчлүүд байна.
- Сумын удирдлага, тухайн ажил хариуцсан албан тушаалтнуудын ОНХС-ийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах мэдлэг чадвар дутмаг, хариуцлага сул байна.
- Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар баталсан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаагүй.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй зарим хөрөнгө оруулалт, ажлууд нь ТЭЗҮ, зураг төсөв нь өмнө хийгдээгүй байхад хөрөнгө батласан.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах талаар хууль, журамд тусгасан заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй.
- Аймгийн Засаг даргын 398 дугаар захирамжийг хэрэгжүүлж ажиллаагүй, байгаль хамгаалах сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаагүй, нягтлан бодох бүртгэлийг хөтлөлт дутуу.
- Байгаль хамгаалах сангийн орлого, зардал, хийгдэх төсөл арга хэмжээнүүдийг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж иргэдийн хурлаар батлуулаагүй зардал

гаргасан нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэсэн заалтыг зөрчсөн.

- Нийгмийн халамжийн сангаас үзүүлж буй тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламж иргэдэд хүрч байгаа боловч гүйцэтгэлд тавих хяналт сул байна.
- Эрүүл мэндийн төвийн эм болон хүнсний материалд биет тооллого хийхэд 7 нэр төрлийн 11.8 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн 12 нэр төрлийн 30.6 мянган төгрөгийн эм, эмэн бүтээгдэхүүн дутагдуулж, 6 нэр төрлийн 25.8 мянган төгрөгийн хүнсний материал, 21 нэрийн 86.7 мянган төгрөгийн эмийг орлогод аваагүй.
- Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5.“хамаарал бүхий этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг; 3.1.2.“хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг” гэсний дагуу хамаарал бүхий этгээдүүд ажиллаж байна.
- Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг явуулахтай холбогдуулан бүтэц орон тооны төлөвлөгөө, зохион байгуулалтыг оновчтой хийгээгүйгээс орон тоо, болон цалинтай холбоотой асуудал үүссэн.
- Сургуулийн дотуур байрны хүүхдийн өдөрлөгийг 104 хүүхэд өдрөөр илүү бичиж 240.8 мянган төгрөгийн зарлага гаргасан хүнсний материал дутагдуулсан.
- Үдийн цайнд олгох ёстой хүнсний материалыг дутуу олгодог хяналтын зөвлөл байгуулаагүй.
- Сургуулийн удирдлага төрийн эд хөрөнгийн хамгаалалт хангалтгүй, Мэргэжлийн хяналтын газрын үлсын байцаагчийн актыг одоо болтол биелүүлээгүй, автомашины бичиг баримтыг гээгдүүлсэн.
- Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2010 оны 361 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтын 1-д “ирцийн бүртгэл” хэсэгт ээлжит хичээл орсон сар, өдөр, суралцагчийн ирцийг тэмдэглэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа зэргээс дүгнэлт хийхэд Хангал суманд хуулийн болон түүнтэй холбогдон гарсан журмын хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрээгүй байна гэж дүгнэлээ.

#### **Хялганат тосгон:**

Хялганат тосгоны Захирагчийн алба нь

- Нэр бүхий 10 ажилтанд 415.0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон, 2 ажилтанд 150.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон, жилийн эцэст тооцоо хийгээгүй, авлагаар тусгаагүй, цалингийн цэсэнд гарын үсэг зуруулаагүй,
- Засаг даргын захирамжгүй 1493.7 мянган төгрөгийг зарцуулсан, ажил үйлчилгээ худалдан авахдаа ХХОАТ-ыг суутган тооцож төлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 1402.8 мянган төгрөг зарцуулсан, анхан шатны баримтгүй 4693.0 мянган төгрөгийн бэлэн мөнгийг олгосон,
- Сумын удирдлага, тухайн ажил хариуцсан албан тушаалтнуудын ОНХС-ийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах мэдлэг чадвар

дутмаг, хариуцлага, хяналт сул, Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар баталсан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг дагаж мөрдөөгүй, ИТХ-аас хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрүүдийн батлагдсан төсөвт өртөгөөс хэтрүүлэн гэрээ байгуулж ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.2.2-д заасан заалтыг зөрчсөн, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тогтоолын 8.6-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, иргэдийн санал аваагүй ажлыг ИТХ-аар баталж санхүүжүүлсэн, ИТХ-ын тогтоолыг нөхөж гаргуулдаг,

- Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаагүй, нягтлан бодох бүртгэлийг хөтлөлт дутуу, аймгийн Засаг даргын 398 дугаар захирамж, сумын Засаг даргын 190 тоот захирамжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
- Суурь боловсролын сургуулийн дотуур байр 599, үдийн цайны хүүхдийн ирцийг 54 хүүхэд өдрөөр илүү бичиж нийт 1443.1 мянган төгрөгийн зарлага гаргасан, хүнсний материалын тооллого хийхэд 2086.5 мянган төгрөгийн хүнсний материал дутагдуулсан,
- Дотуур байрны багшийн ирцийн дэвтэр дутуу, жижүүр хүлээлцсэн тэмдэглэл байхгүй, нийт 2923 хүүхэд өдөрлөгийн ирцийн зөрүүтэй байгаа нь тухайн багшийн ажлын хариуцлага суларсан,
- Нүүрс түлэх зориулалтгүй зууханд 3060.0 мянган төгрөгөөр 18 тн нүүрс худалдан авсан бөгөөд 2013 оны санхүүгийн тайлангаар уг нүүрсийг зарлагадаж дууссанаар хуурамч баримт бүрдүүлсэн,
- Суурь боловсролын сургууль үүсэн байгуулагдсаны 40 жилийн ойн хандивыг хувь хүний дансаар дамжуулсан нь Төсвийн тухай хуулийн 25.12 дахь ". . . тусламжийн орлогыг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна.", 25.6 дахь "Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална.", 25.7 дахь "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажлаагүй,
- Цэцэрлэгийн багш нарын ирцийн бүртгэл няравын өдөрлөгтэй зөрж хүүхэд өдөрлөг илүү бичиж хүнс зарлагдсан, "Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 төгрөгөөр ... тогтоосугай" гэсэн дундаж нормативыг зөрчиж 350.6 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан,
- Эрүүл мэндийн төв нь 2014 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлээс бараа материалын тайлангийн эм боох материалын үлдэгдэл 250.3, аж ахуйн материалын үлдэгдэл 2396.2 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн, биет тооллого хийхэд эмийн материалаас 106.9 мянган төгрөгийн эм тариа, хүнсний бүтээгдэхүүнээс 23.9 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн дутагдсан, тус газрын дуудлагын дэвтрийг замын хуудастай харьцуулан үзэхэд нийт 1250.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 501.5 мянган төгрөгийн шатахууныг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчил илэрсэнтүл тосгоны санхүүгийн ажилтнуудын сахилга хариуцлага, төрийн хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, цаашид ажилдаа хариуцлагатай хандах шаардлагатай гэж дүгнэлээ.

**Могод сум:**

Могод сумын биелэх боломжтой тодорхой нэр төрлийн татварын орлогууд 17.7-87.0 хувиар тасарсан, мод түлээ бэлтгэх эрхийн бичгийг ихээр олгож Ойн тухай хуулийн 34.1 дэх заалтыг зөрчиж аймаг, сумын ИТХ-аас баталсан “Ойгоос бэлтгэх модны дээд хязгаар”-ыг хэтрүүлсэн, сумын ИТХ нь Төсвийн тухай хуулийн 34.2.1 дэх заалтыг зөрчин төлөөлөгчид цугларах боломжгүй гэсэн шалтгаанаар хуралдааныг хойшлуулж төсөвт тодотгол хийгээгүй, орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд нь гэрээнд заагдсан хугацаанд ажлыг гүйцэтгэж дуусгадаггүй, хугацаа хэтрүүлдэг, ажил гүйцэтгэх гэрээнд хугацаа хэтэрсэн тохиолдолд тооцох хариуцлага, алдангийг тодорхой заагаагүй, ажлын үе шатны хяналт сул, дууссан ажил үйлчилгээг хүлээн авсан албан ёсны эрхийн акт баримтгүй, тендерт оролцож шалгараагүй бүл, аж ахуй нэгж байгууллагын ирүүлсэн бичиг баримт, материалыг худалдан авах ажиллагааны баримт бичигт архивлаагүй, сумын төвийн камер техникийн нөхцөл, гэрэлтүүлгээс шалтгаалан шөнө, оройн харанхуй орчинд камерт дүрс харах боломжгүй, цахилгааны хэлбэлзлээс шалтгаалан тог бууруулагч шатдаг зэргээр суурь нөхцөл үүсээгүй байхад үр дүн багатай ажилд хөрөнгө зарцуулж хүлээн аваад жил болж байхад 1 камераас бусад нь ашиглалтгүй байна.

Суурь боловсролын сургуулийн дотуур байр 45, үдийн цайны хүүхдийн ирцийг 1090 хүүхэд өдрөөр илүү бичдэг, хүнсний материалын тооллогоор материал дутагдуулсан, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2010 оны 361 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтын 1-д “ирцийн бүртгэл” хэсэгт ээлжит хичээл орсон сар, өдөр, суралцагчийн ирцийг тэмдэглэнэ” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй, Цэцэрлэгийн хүнсний материалд биет тооллого хийхэд материал дутагдуулсан, ажиллаагүй үед хүүхдийн өдөрлөг бичиж хүнс зарлагдсан, өдөрлөгийг 2014 оны 12 дугаар сарын 25-наар тасалбар болгон ажлын 4 хоног буюу 296 хүүхдийн 488.4 мянган төгрөгийг тайлан тооцоонд дутуу тусгасан зэрэг зөрчил илэрсэн тул сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

#### **Хутаг-Өндөр сум:**

Хутаг-Өндөр сумын уурын зуух нь 1982 оноос “Магсаржав САА” –н уурын зуух нэртэйгээр 1991 оноос 2014 оны 04 дүгээр сар хүртэл ЗДТГазрын дэргэдэх Дулааны төв гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсныг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолоор “Илчит Хутаг” ОНӨААТҮГазар болгон үйл ажиллагааны дүрмийг баталжээ. “Илчит хутаг” ОНӨААТҮГазар нь 2014 онд Цэцэрлэг, Сургууль, ЗДТГазар, Соёлын төв, Тэмүүлэл эмийн сан, Мөнх-Ундарга эмийн санг дулаанаар хангах гэрээ байгуулж ажилласан байна.

Булган аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 15-ны 01 дүгээр тогтоолоор Хутаг-Өндөр сумын дулааны төвийн харьяа төвлөрсөн халаалтанд холбогдсон харилцагч байгууллагын 1 метр куб эзэлхүүний дулааны эрчим хүчний үнийг 576 төгрөгөөр тогтоон баталсны дагуу 2014 онд халаалтын орлогыг гэрээнд тусгагдсан метр куб эзэлхүүний хэмжээгээр 140345.2 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 117634.1 мянган төгрөгийн орлого орж 26754.2 мянган төгрөгийн авлага, 4453.2 мянган төгрөгийн өглөгтэй боловч 2014 онд санхүүгийн тайлан бүртгэл гаргаж өглөг авлагыг баталгаажуулаагүй, харилцагч байгууллагуудын 2014 оны санхүүгийн тайланд өр, авлагыг тусгаж тайлагнаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай”

хуулийн 19.1.4 “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалтыг зөрчижээ.

2014 онд “Шинэ сум” төслөөр Хутаг-Өндөр сумын дулаан халаалтын шугамын шинэчлэлтийг хийхээр “Эрхэт Наран” ХХКомпани шалгарсан байна. Дулааны шугам сүлжээг сольж хүчин чадлыг нэмэгдүүлэх явцад төсөвт байгууллагуудын хуучин санхтехник, паарнууд ачааллаа даахгүй хагарч ашиглах боломжгүй болсонд “Эрхэт наран” ХХК-аас сумын шугам сүлжээнд ашиглагдаж байсан цаашид ашиглах боломжтой трубаны үнэнд 10000.0 мянган төгрөгийг “Илчит-Хутаг” ОНӨААТҮГазрын дансанд 11 дүгээр сарын 24-ны өдөр шилжүүлсэнийг Сургуульд 2000.0 мянган төгрөг, Эрүүл мэдийн төвд 1000.0 мянган төгрөг, цэцэрлэгт 1000.0 мянган төгрөг, ЗДТГазарт 2000.0 мянган төгрөг, Соёлын төвд 3000.0 мянган төгрөг, халуун усанд 1000.0 мянган төгрөгийг бэлнээр олгож сантехникийн хүчин чадалаа өсгөхөөр төсөвт байгууллагууд засварын материал авсан боловч орлогодож аваагүйд албан шаардлага бичлээ.

“Илчит-Хутаг” ОНӨААТҮГазар нь “Шинэ сум” төслөөр халаалтын тогоо, дулааны шугамын шинэчлэлт хийгдэж дансны үнэ нь 25000.0 мянган төгрөгийн 1ш БЗУ-100 маркын халаалтын тогоо, нэг бүрийн үнэ 58000.0 мянган төгрөгийн 2ш КНР 90-60-6 маркын халаалтын тогоо, 22000.0 мянган төгрөгийн 1600м дулааны шугамыг ашиглалтаас хассан байна. Ашиглалтаас хассан эдгээр хөрөнгө нь хариуцсан эзэн байхгүй, санхүүгийн тайлан гаргаж данс бүртгэл хөтөлдөггүйн улмаас элэгдэл хорогдол дансны үнэ байхгүй байгаа нь төрийн өмчид хайхрамжгүй хандсан ноцтой зөрчил байна. Аймгийн ИТХ-ын 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журмын дагуу шийдвэрлэх шаардлагатай байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлуудыг сонгон шалгаруулахдаа гэрээг байуулсан он сар өдөргүй, тухайн тендерт саналаа ирүүлсэн шалгараагүй бүлийн тендерийн баримт бичиг байхгүй, албан ёсны хүлээн авсан актгүйгээр ашиглалтанд оруулж, санхүүжилтийг бүрэн олгосон,
- ✓ “Тэмдэг, тэмдэглээ” төслөөр худалдан авсан замын тэмдэг тэмдэглэгээг одоог хүртэл ашиглахгүй агуулахад хадгалж байгаа,
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх 31 ажил сумын ИТХ-аар батласнаас 20 ажил буюу 67.7 хувь нь зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй баталсан, хэрэгжсэн 20 төсөл арга хэжээг хүлээж авсан акт байхгүй,
- ✓ Сум дундын ойн анги нь Ойн тухай хуулийн 18.3.1.-д заасанчлан ойгоос мод бэлтгэх талбайн тусгаарлалтаас ойн санд төвлөрөх хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй,
- ✓ “Илчит Хутаг” ОНӨААТҮГазар нь 2014 онд санхүүгийн тайлан, анхан шатны баримт бүрдүүлэлт дутуу, няравын тайлан гаргаагүй, зэрэгт үндэслэн байгууллагуудын төсвийн хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоод болон санхүүгийн албаны хяналт сул зэргээс сумын хэмжээнд хууль, тогтоомжийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай гэж дүгнэлээ.

**Бугат сум:**

#### Аудитаар

- Орон нутгийн төсвийн орлогыг 3277.4 мянган төгрөгөөр тасалсан, татварын орлогыг бүрдүүлэх нөөц боломжийг бүрэн ашиглаж үр ашигтай төлөвлөөгүй, өмнөх оноос гүйцэтгэлээр хувиараа аж ахуй эрхэлсний орлогын албан татвар 1933.6, орлого тодорхойлох боломжгүй иргэний орлогын албан татвар 282.6, хувиараа материал бэлтгэсний орлогын албан татвар 1329.4, улсын тэмдэгтийн хураамж 402.4, хүү торгуулийн орлого 4714.6 мянган төгрөгөөр тус тус буурсан, аймгийн ИТХ-аас хэрэгцээний 2660 м.куб мод бэлтгэхээр баталсныг гүйцэтгэлээр 223.9 м.куб мод илүү олгож Ойн тухай хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн ,
- “Элгэн Бугат” ОНӨХХК нь сумын Засаг даргын тамгын газрын түлш халаалтын үнэ Хутаг-Өндөр сумаас 1996 төгрөг, “Булган Мээж” ХХК-иас 1071 төгрөгөөр тус тус илүү, халаалтын үнийн нэгдсэн бодлогогүй, ХААН банкны салбараас 1 м.куб-ийг 1500 төгрөгөөр тооцсон боловч халаалтын үнийг ТУЗ-аар хэлэлцэж тогтоогоогүй, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 3-р сарын 02-ны өдрийн 68 тогтоолын хавсралтанд /шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 10 сая төгрөг байна/ заалтуудыг ноцтой зөрчиж ямар нэгэн эрх зүйн акт шийдвэргүй, ил тод байдлыг хангаагүй “HINO RANGER” ачааны автомашиныг иргэн Г.Баатархүүгээс 20.0 сая төгрөгөөр худалдаж авсан,
- Шатахуун түгээх станцыг 2014 оны 6-р сарын 30-ний байдлаар 220 л А-80 шатахуун үлдэгдэлтэй иргэн Б.Нарангэрэлд сумын Засаг даргын орлогчийн аман шийдвэрээр түрээслүүлсэн ба 7 иргэнээс 1240.6 мянган төгрөгийн авлагатай гарсан боловч одоог хүртэл барагдуулаагүй, санхүүгийн тайлан балансад тусгаагүй, туузан “Тайга” хөрөөний хүчин чадал нь хоногт 2 м.куб банз зүсдэг бөгөөд 2014 онд 2 удаа 640.0 мянган төгрөгөөр хөрөөний ир авч шинээр тавьсан байгаа зэргээс үзэхэд зүссэн банз, авсан модны тооцоо их хэмжээгээр зөрүүтэй,
- “Элгэн Бугат” ОНӨХХК-ий захирал сумын төвийн 5 худаг, халуун усны ажилчидтай “хөлсөөр ажиллуулах гэрээ” байгуулахдаа 1-6-р сард 40.0, 7-12-р сард 80.0 мянган төгрөгийн урамшуулал олгохоор тусган 4569.6 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, халуун ус, худаг ажиллууж байгаа ажилчид компаний дансанд орлогоо тушаадаггүй өөрсдөө авч байгаа нь Монгол улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8-р зүйлийн заалтуудыг ноцтой зөрчсөн,
- Компаний дүрмийн 11 дүгээр зүйлийг зөрчин аудитын хороог одоо болтол томилж ажиллуулаагүй, НББ-ийн тухай хуулийн 4.1.1-ийг зөрчин компаний НББ нь олон улсын стандартад нийцээгүй, 4.1.2.2 дугаар заалтыг зөрчиж санхүүгийн тайланд 6799.8 мянган төгрөгийн авлага, мөн 4958.4 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр тусгасан нь хариуцах эзэнгүй, тооцоо нийлж актгүй, үндэслэлгүй авлага, өглөг үүсгэсэн, эзэмшигчдийн өмчийн тайланд хувийн өмчийн хэсэгт 3000.0 мянган төгрөг тусгасан, туслах журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй, анхан шатны баримт бүрдүүлж, няравын тайлан гаргаагүй,
- Туузан хөрөө /Тайга/ ажиллуулахдаа ойг ашиглах чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэж банз зүссэн, компаний ТУЗ-ийн хурал нэг ч

- хийгээгүй 2013, 2014 оны санхүүгийн, болон үйл ажиллагааны тайлан хэлэлцүүлээгүй, компаний захирал, нягтлан бодогч ажилдаа хайхрамжгүй, мэдлэг чадвар дутмагаас болж НӨАТ буцаалт 2443.5 мянган төгрөгийн тооцоо хийгээгүй,
- Аймгийн ИТХ-аар төсөвт тодотгол хийж орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг 21.6 сая төгрөгөөр хасч 291.0 сая төгрөгөөр баталсаны дагуу төсөвт тодотгол хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 34.2 дахь "Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:", 34.2.1 дэхь "дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон;" гэсэн заалтуудыг зөрчсөн.
  - Хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 06 ны өдрийн 43 дугаар тогтоолын 6.8, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "ТБОНӨХБАҮХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам", Төсвийн тухай хуулийн 60.3.6-д заасан заалтыг тус тус зөрчсөн, тухайлбал "Элгэн бугат" ОНӨХХК-д 2013 оны хөрөөны үнийн үлдэгдэл санхүүжилт гэх 4973.7 мянган төгрөгийг шилжүүлэн зориулалт бусаар зарцуулсан, "Гэгээрэл" албан бус боловсролын халаалтын зардалд 420.0 мянган төгрөгийг шилжүүлсэн,
  - Хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй 16 төсөл арга хэмжээг төлөвлөсөн,
  - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлуудыг сонгон шалгаруулахдаа гэрээг байуулсны дараа захирамж гаргадаг, албан ёсны хүлээн авсан актгүйгээр ашиглалтанд оруулсан, санхүүжилтийг бүрэн олгосон,
  - Худалдаа үйлчилгээний төв, Эргэлтийн эмийн сан барих ажлууд дууссан боловч одоог хүртэл ашиглалтанд оруулаагүй байгаа нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тооцоолсон үр ашиг, үр дүн гарч байгаа эсэхийг хянаж үр дүнг тооцоолон ажиллах, гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй,
  - Хадлангийн салааны өвсний хаман боогч авах тендерт "Их Бугат уул" ХХК-ийг сонгон шалгаруулж ЗХУ-д 1986 онд үйлдвэрлэгдсэн "Киргизстан ТРД-1,6" маркийн өмнө нь ашиглаж байсан өвс хаман боогчийг 10000.0 мянган төгрөгөөр худалдаж авсан нь 2014 онд Баян-Агт сум орон нутгийн хөгжлийн сангаас бага оврын шинэ өвс хаман боогчийг "Вест агро интернейшил" ХХК-иас нэг бүрийг нь 11685.0 мянган төгрөгөөр авсан байхад үйлдвэрлэгдээд 28 жил болсон өвс хаман боогчийг авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, "Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн" барих ажилыг 2013 онд 29500.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөн 2014 онд 24885.4 мянган төгрөгийн гүйцэтгэл гарган санхүүжүүлсэн боловч 3600.0 мянган төгрөгийн хашааг 2013 онд барьсан гэж хуурамч бичиг баримт бүрдүүлсэн,

- Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаагүй, нягтлан бодох бүртгэлийг хөтлөлт дутуу, аймгийн Засаг даргын 398 дугаар захирамж, сумын Засаг даргын 190 тоот захирамжийг бүрэн хэрэгжүүлээгүй,
- Хиймэл шүд хийлгэсэн иргэдийн материалтай танилцахад “Оюухай” шүдний эмнэлэгт шүд хийлгэсэн иргэдийн үйлчилгээний хөлс 2012 онд 114.0, 2013 онд 150.0, 2014 онд 120,0 мянган төгрөг буюу тогтмол дээд, доод тагнай 28 шүд гэсэн нь халамжийн санд хамрагдах иргэдийн мэдээллийг нэгдсэн санд бүртгэхдээ бодит байдлыг харгалзан үздэггүй дотоод хяналт суларсан,
- Сумын 90 жилийн ойн баяр наадамд зарцуулсан хөрөнгийн 83.78 хувь буюу 58194.7 мянган төгрөгийн анхан шатны баримт нь төрийн сангаар хянагдаагүй, 6830.0 мянган төгрөгийн төлбөрийн хүсэлт нэгдүгээр гарын үсэггүй байгаа нь Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолыг зөрчиж хувь хүний дансаар 28 удаагийн нийт 57084.1 мянган төгрөгийн гүйлгээ гарснаас ЗДТГазрын нярав Ц.Оюунтуяагийн арилжааны банкны дансаар 19 удаагийн 38700.4 мянган төгрөг дамжуулан гаргасан,
- Хүүхдийн цэцэрлэг Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 94 дүгээр тогтоолыг зөрчиж 7 хүүхдийн 6101.2 мянган төгрөгийн хувьсах зардал илүү авч зарцуулан, Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолыг зөрчиж 90.5 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан, цэцэрлэгийн хүнсэнд биет тооллого хийхэд 61.4 мянган төгрөгийн материал дутагдуулсан, зун цэцэрлэгийн хувилбарт сургалтаар 2-р багт ажилласан гэр цэцэрлэгийн хоолны өдөрлөг байгаа боловч хүүхдийн ирц, бүртгэл байхгүй, 412.6 мянган төгрөгийн шатахууны зардалд тамга тэмдэг, гарын үсэг дутуу замын хуудас бүрдүүлсэн,
- Сургуулийн захирал нь өөртөө үр чадварын нэмэгдэл олгох шийдвэр гарган 138.8 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл авсан, эд хариуцагчийн хүнсний материалд биет тооллого хийхэд 31.4 мянган төгрөгийн хүнс дутагдуулсан, Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолыг зөрчин нэг хүүхдэд өдөрт дунджаар 2298 төгрөгийн хүнс олгосон, дотуур байрны хүүхдийн ирц, хүнсний өдөрлөгөөс 103 хүүхэдээр илүү, үдийн цайны хүүхдийн ирцийн бүртгэлийг өдөрлөгтэй нь тулган үзэхэд нийт 141 хүүхэд өдрийн 84.6 мянган төгрөгийн хүнс илүү зарлагадсан,
- Сургууль нь жолоочийн тооцооны хуудас хөтөлсөн ч тамга тэмдэг, спидометрийн заалт, гарын үсэг дутуу 2600.0, бүртгэлийн данснаас хийгдсэн 56133.8 мянган төгрөгийн гүйлгээ, төлбөрийн хүсэлтэнд даргын гарын үсэг болон тамга тэмдэг, гүйлгээ хийгдсэн нь үнэн болох төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, тэмдэг, гүйлгээ хийсэн он, сар, өдөргүй баримт байгаа зэргээс дүгнэлт хийхэд Бугат суманд хуулийн болон түүнтэй холбогдон гарсан журмын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэлээ.

Аудитаар 214924,1 мянган төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 25417,6 мянган төгрөгийн төгрөгийн 15 акт, 189506,5 мянган төгрөгийн 10 албан шаардлага, сумын ИТХ дарга, сумын Засаг дарга, сумын Засаг даргын орлогч, санхүү тасгийн дарга, “Хусхан”

хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, суурь боловсролын сургуулийн захирал, “Элгэн Бугат” ОНӨХХК захирал, нягтлан бодогч нарт 16 хугацаатай зөвлөмж хүргүүлж ажиллаа.

**Гүйцэтгэл, нийцлийн аудитын** дүнгээс үзэхэд төсвийн эрх захирагч нар төсвийн орлогын төлөвлөхдөө байгаа нөөц боломжийг бүрэн дайчлаагүй, өмнөх оны татвар, хураамжийн дутууг бүрэн тусгадаггүй, татварын орлого бүрдүүлэлтийг тооцдог, төлөвлөдөг мэргэжилтнүүдийн тооцоог хянадаггүй, төсвийн зарцуулалтанд арвилан хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, сахилга хариуцлагыг сайжруулах, терийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх талаар санаачлага муутай ажиллаж байгаагийн дээр төсөвт байгууллагын менежерүүд үр дүнгийн гэрээг нарийн тооцдоггүй, урамшууллыг ажлыг үр дүнтэй уялдуулан бодитой үнэлдэггүй хавтгайруулан олгодог, байгууллагын санхүүгийн дотоодын хяналт, анхан шатны бүртгэл хетлэлт болон нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сулруулснаас бэлэн мөнгийг хувийн харилцах дансаар дамжуулдаг, төсвийг хэтрүүлэн зарцуулдаг, зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлдэг, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр херенгэ бэлтгэдэг зэрэг нийтлэг зерчил, дутагдал буурахгүй давтагдсаар байгаад төсвийн ерөхийлөн болон төвлөрүүлэн захирагч нар шууд захирагч нарт бодитой хариуцлага хүлээлгэдэггүйгээс төсвийн зарцуулалтын үр дүнд дорвитойөөрчлөлт гарахгүй байна гэж дүгнэлээ.

Нөгөө талаас орлогыг давуулан биелүүлсэн, төсвийн хэмнэлт гаргасан төсөвт захирагч нарт шагнал, урамшууллын тогтолцоо байхгүй харин ч хэмнэсэн мөнгийг нь хурааж авдаг хуулийн заалт нь төсвийг үрэлгэн зарцуулахад нөлөөлсөөр байна.

## АУДИТЫН ГАЗАР